



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 26 өдөр

Дугаар A/41

Улаанбаатар хот


Г Т
Журам батлах тухай

Монгол Улсын Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хуулийн 12 дугаар зүйл, Монгол Улсын Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Гэрээр сувилахуйн тусlamж, үйлчилгээ үзүүлэх журмыг нэгдүгээр, Гэрээр сувилахуйн тусlamж, үйлчилгээ үзүүлэх захиалга бүртгэлийн хуудсыг хоёрдугаар, Гэрээр сувилахуйн тусlamж, үйлчилгээ үзүүлсэн тухай тэмдэглэлийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга бүх өмчийн хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусlamжийн газар /Я.Баянжаргал/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/-т тус тус даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2004 оны "Журам батлах тухай" 136 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД

А.ЦОГЦЭЦЭГ





ГЭРЭЭР СУВИЛАХҮЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл.

1.1 Анхан шатны тусlamж, үйлчилгээг хүн амд ойртуулах, архаг, хүнд, хэвтрийн өвчтэй, урт хугацаанд асаргаа, сувилгаа, шаардлагатай иргэдэд гэрээр үзүүлэх тусlamж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад тушаалын зорилго оршино.

1.2 Гэрээр үзүүлэх сувилахуйн тусlamж, үйлчилгээнд өмчийн олон хэлбэрт суурисан тусlamж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж, дэмжин хөгжүүлэх замаар анхан шатны тусlamж, үйлчилгээний чанарыг сайжруулна.

1.3 Гэрээр сувилахуйн тусlamж, үйлчилгээ үзүүлэх сувилагч нь мэргэжлийн эрх бүхий, өмчийн олон хэлбэрийн сувилахуйн болон эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын орон тооны сувилагч мэргэжилтэн байна.

1.4 Гэрээр сувилахуйн тусlamж, үйлчилгээг үзүүлэхэд энэхүү журам болон бусад холбогдох хууль, дүрэм, журмыг баримталж ажиллана.

Хоёр. Гэрээр сувилахуйн тусlamж, үйлчилгээ үзүүлэх тохиолдол.

2.1 Үйлчлүүлэгч өөрөө болон түүний асран халамжлагч энэхүү тушаалын 9 дүгээр заалтад нийцсэн тусlamж, үйлчилгээг гэрээр авахаар захиалга өгч, хүсэлт гаргасан,

2.2 Өрхийн эрүүл мэндийн төв, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн захиалгаар хийх гэрийн товлолт эргэлт,

2.3 Зарим эмчилгээ, сувилгааг гэрийн нөхцөлд үргэлжлүүлэн хийх эмчийн болон эмнэлгийн байгууллагын заалттай үйлчлүүлэгч зэрэг нь сувилагч гэрээр тусlamж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны үндэс болно.

Гурав. Гэрээр сувилахуйн тусlamж, үйлчилгээ үзүүлэхэд баримтлах зарчим.

Гэрээр сувилахуйн тусlamж үйлчилгээ үзүүлэгч сувилагч нь:

3.1 Хүн, түүний үнэт зүйлсийг хүндэтгэн үзэх үзэл, үйлчлүүлэгчийн тэгш эрхийн зарчимд сууриссан сувилахуйн тусlamж, үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

3.1.1 Нийгмийн анги давхарга, баян ядуу, арьс өнгө болон шашны итгэл үнэмшлээр ялгаварлан гадуурхах үзлээс ангид байна,

3.1.2 Хүнлэг, энэрэнгүй, ил тод, шударга байна,

- 3.1.3 Үйлчлүүлэгчийн нэр төр, хувийн нууцлалыг хүндэтгэнэ,
 - 3.1.4 Үйлчлүүлэгчийн эрхийг дээдэлнэ.
- 3.2 Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм, хэмжээг баримталж ажиллана.
- 3.3 Асаргаа сувилгааны үндсэн зарчмыг баримталж ажиллана. Үүнд:
 - 3.3.1 Үйлчлүүлэгчийн хүрээлэн буй орчны эрүүл мэнд, тав тухыг хангана,
 - 3.3.2 Үйлчлүүлэгчийн өдөр тутмын хэрэгцээт хэмжээний хоол, хүнсийг тооцон, зааж сургана, хооллоно,
 - 3.3.3 Сэтгэл зүй, шинж тэмдгийн асаргаа, сувилгаа, өөрийгөө асрах чадварыг нь хөгжүүлнэ,
- 3.4 Гэрээр тусlamж, үйлчилгээг үзүүлэхдээ халдварын сэргийлэлт, хяналтын дүрмийг нарийвчлан баримтална.
- 3.5 Сувилахуйн тусlamж, үйлчилгээ үзүүлсний төлөө нэмэлт төлбөр, шан харамж авахаас татгалзана.

Дөрөв. Гэрээр сувилахуйн тусlamж, үйлчилгээ үзүүлэх сувилагчийн зайлшгүй эзэмшсэн байх чадвар.

- 4.1 Гэрээр сувилахуйн тусlamж, үйлчилгээ үзүүлэх сувилагч /цаашид сувилагч гэх/ нь ахлах сувилагч, зөвлөх сувилагч болон бусад мэргэжлийн багийн удирдлага дор ажиллах, мэргэжлээрээ 3-аас дээш жил ажилласан сувилагч байна.
- 4.2 Сувилагч нь эмнэлгийн ажилтны ёс зүй, мэргэжлийн ур чадвар, бусад харилцааны ур чадварт тусгайлан суралцсан байна. Үүнд:
 - 4.2.1 Асуулт асууж, харилцаа тогтоох чадвар,
 - 4.2.2 Сонсох чадвар,
 - 4.2.3 Эмнэлгийн ажилтны ёс зүйг баримтлах чадвар,
 - 4.2.4 Асуудал тодорхойлж, дүгнэлт хийж, шийдвэр гаргах ур чадвар,
- 4.3 Зөвлөгөө өгөх, ур чадвар.
 - 4.3.1 Үйлчлүүлэгч түүний гэр бүлтэй зелдэг боловсон, харилцаж, ярилцах, зөвлөгөө өгөх ур чадварыг сувилагч бүрэн эзэмшсэн байна. Үүнд:
 - 4.3.1.1 Сайн сонсогч,
 - 4.3.1.2 Хувийн нууцлалыг хадгалагч,
 - 4.3.1.3 Харилцан ярилцагч,
 - 4.3.1.4 Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэгч,
- 4.4 Багаар ажиллах чадвар,
- 4.5 Сувилахуйн түгээмэл үйлдлийн стандартын дагуу гардан үйлдлийн чадвар,
- 4.6 Сувилахуйн тусlamж, үйлчилгээг сувилгааны үйл ажиллагааны дагуу хийх мэргэжлийн ур чадвар.

Тав. Гэрээр сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлэх сувилагчийн эрх.

- 5.1 Үйлчлүүлэгч болон түүний асран халамжлагчаас гэрт үзүүлэх тусламжид шаардлагатай нөхцөл, онцлог, заалтуудыг урьдчилан танилцуулж, зөвшөөрөл авах,
- 5.2 Сувилахуйн тусламж, үйлчилгээг гэрээр үзүүлэхэд тохиромжтой нөхцөл бүрдүүлэх талаар гэр бүлийн гишүүдэд зөвлөх, сануулах,
- 5.3 Үйлчлүүлэгч согтуу, мансууруулах бодис хэрэглэсэн, сувилагчийн бие, сэтгэлд дарамт үзүүлсэн буюу үзүүлэх хандлагатай нөхцөл байдалд байгаа, танхайрах үйлдэл гаргасан гэх мэт хэвийн бус нөхцөл байдалтай үед сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлэхээс татгалзах ба энэ тухай тэмдэглэл хөтөлж, баталгаажуулах,
- 5.4 Үйлчлүүлэгчийн өөрийн худалдаж авсан эм, тариа, дусал тариа, бусад эм, эмнэлгийн хэрэгслийн нэр хаяг, үйлдвэрлэсэн, хүчинтэй байх хугацаа нь тодорхойгүй, түүнийг хэрэглэх талаар эмчийн бичсэн заалтгүй тохиолдолд үйлчилгээ үзүүлэхээс татгалзах,
- 5.5 Үйлчлүүлэгч, түүний гэр бүлийн гишүүдэд тухайн үйлчлүүлэгчийн өвчин, эмгэгийн талаар тайлбарлах, асаргаа, сувилгааны талаар мэдлэг олгох, зөвлөгөө өгөх,
- 5.6 Сувилагч тухайн тусламжийг үзүүлэхэд шаардлагатай олон мэргэжлийн баг бүрдүүлэн тусламж, үйлчилгээг гэрээр үзүүлэх.

Зургаа. Гэрээр сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлэх сувилагчийн үүрэг.

- 6.1 Сувилахуйн тусламж, үйлчилгээг гэрээр үзүүлэхдээ “Эрүүл мэндийн технологи-Эмчилгээ, оношилгооны түгээмэл үйлдлүүд” MNS 4621:2008 болон батлагдсан бусад стандарт, эмнэл зүйн заавар, удирдамжийг баримтална.
- 6.2 Зөвхөн энэхүү тушаалд заагдсан сувилахуйн тусламж, үйлчилгээний заалтаар тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
- 6.3 Үйлчлүүлэгчид сувилахуйн мэргэжлийн тусламж, үйлчилгээг нэмэлт зовиур учруулахгүй, чанартай, шуурхай үзүүлнэ.
- 6.4 Сувилагч нь сувилахуйн тусламж үйлчилгээг бие дааж үзүүлэх чадвартай, нийгмийн эрүүл мэндийн сувилахуй, хүүхэд, настны сувилахуйн чиглэлээр мэргэшсэн бол давуу тал болно.
- 6.5 Сувилагч мэдээллийг үнэн зөв авах, бүртгэх, мэдээллийн нууцлалыг хангах, зөв боловсон харилцах, эргэн мэдээлэх, холбогдох хүмүүст танилцуулах, шаардлагатай тохиолдолд эргэх холбоо үүсгэх, утас, цахим хаягийг тодорхой байлгана.
- 6.6 Үйлчлүүлэгчид тусламж, үйлчилгээний явцад анхаарах зүйлс, өвчиний хүндрэл, нөхцөл байдал, тавиланг тайлбарлан ойлгуулах, эмчилгээний явц, үр дүн, гарч болох эрсдэл, хүндрэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжөөр хангана.
- 6.7 Хүндрэлтэй байж болзошгүй ажилбарыг үйлчлүүлэгчид бүрэн тайлбарлаж, зөвшөөрөл авах, олон хувилбараас сонголт хийлгэх, харилцан ярьж тохиролцено.

6.8 Эмийн эмчилгээг гэрээр хийхээр бол үйлчлүүлэгчид эмийн бодисыг ямар нөхцөлд, хэрхэн хадгалах, уух аргачлалыг сайтар тайлбарлан, эмийн гаж нөлөөний талаар мэдээлэл өгнө.

6.9 Сувилах төлөвлөгөө болоод дараагийн алхмыг тодорхой танилцуулна.

6.10 Өөрийн мэдлэг, мэргэжлээ байнга дээшлүүлж идэвх, санаачилгатай ажиллана.

Долоо. Гэрээр сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлэх сувилагчийн харьялах байгууллагын хүлээх үүрэг:

7.1 Гэрээр сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлэх сувилагчийн харьялах байгууллага (цаашид байгууллага гэх)-аас гэрээр үзүүлж буй сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, тогтмол хяналт, үнэлгээ хийж, үр дүнг тооцож ажиллана.

7.2 Байгууллага нь гэрийн эмчилгээ, сувилгаанд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, хөтлөх анхан шатны маягт, бичиг баримтыг тасралтгүй хангана.

7.3 Харьяа хүн амын дунд зонхилон тохиолдох өвчлөлийн байдал, өртөмтгий бүлэг, настан, нийгмийн эмзэг бүлэгт хамрагдах хүмүүсийн судалгааг тусгайлан хийж тэдгээрт зориулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хэрхэн хүргэх төлөвлөлтийг хийнэ.

7.4 Гэрээр сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлэх сувилагчийн харьялах байгууллагаас сувилгаа, асаргаанд дэвшилтэт арга хэрэгсэл, үйлчилгээний соёлыг нэвтрүүлэхэд мэргэжилт арга зүй, дэмжлэгт удирдлагаар хангаж ажиллана.

7.5 Гэрээр үзүүлсэн сувилахуйн тусламж, үйлчилгээний үр дүн, гүйцэтгэлийн үзүүлэлтийг тогтмол дүгнэж, байгууллагын удирдлагаар зөвлөлийн хуралд тогтмол мэдээлж, тайлагнана.

7.6 Үйлчлүүлэгчийг эмчилгээ, сувилгааны талаар /утсаар болон бусад/ зөвлөгөө авах, холбоо барих, товтолт үйлчилгээг үзүүлэх мэдээллээр бүрэн хангасан байна.

Найм. Гэрээр тусламж, үйлчилгээ үзүүлэх сувилагчийн үйл ажиллагаа.

8.1 Гэрээр сувилахуйн тусламж, үйлчилгээг үзүүлэх сувилагч нь:

8.1.1 Эрүүл мэнд, спортын сайдын 2013 оны "Эрүүл мэндийн статистик мэдээллийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 450 дугаар тушаал,

8.1.2 Эрүүл мэндийн сайдын 2015 оны "Журам батлах тухай" 497 дугаар тушаал,

8.1.3 Эрүүл мэндийн сайдын 2013 оны "Удирдамж батлах тухай" 472 дугаар тушаал болон энэхүү тушаалыг баримтална.

8.2 Гэрээр сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа сувилагч нь энэхүү тушаалын хоёр, гуравдугаар хавсралтаар баталсан бүртгэл, тайлангийн маягтыг хөтлөнө.

8.3 Үйлчлүүлэгчийн өвчин архаг, хүнд, урт хугацаанд асаргаа, сувилгаа шаардлагатай тохиолдолд нэмэлтээр ЭМС-ын 2013 оны 450 дугаар тушаалд заасан:

- 8.3.1 Эмчлүүлэгчийн амин үзүүлэлтийг хянах хуудас (СТ-1а/б)
- 8.3.2 Сувилагч, эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх хуудас (СМ1-11)
- 8.3.3 Сувилгааны тэмдэглэл (СМ-2-12)
- 8.3.4 Өвдөлт хянах хуудас (СМ-3-13)
- 8.3.5 Шингэний баланс хянах хуудас (СМ-4-14)-уудаас сонгомлоор авч хэрэглэж болно.

8.4 Гэрээр сувилахуйн тусlamж авах үйлчлүүлэгчийн талаарх мэдээлэлтэй урьдчилан танилцана.

8.5 Үйлчлүүлэгчтэй холбоо барьж, очих цагаа тохирох, хэрэглэгдэх зүйлсийг бэлтгүүлэх зорилгоор зарим тодруулга авч, зөвлөгөө өгнө.

8.6 Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэнэ. (ЭМС-ын 2013 оны 472 дугаар тушаалын Б.4 Гэрийн сувилгааны иж бурдлийн цүнх, болон бусад хэрэглэгдэх зүйлс, хөтлөх бичиг баримт)

8.7 Үйлчлүүлэгчид хийх үйлдлийн зорилгыг тайлбарлах, биеэ хэрхэн бэлтгэх, ажилбарын эцэст гарах үр дүнг ойлгуулах, хянах хуудас, зааварчилгаагаар хангана.

8.8 Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн асуудлаар харилцан ярилцаж, мэдээллийг нь сончч, бодит ба бодит бус мэдээллийг цуглуулж, олж авсан мэдээллийг бүлэглэж, гол асуудлыг бичиж тэмдэглэнэ.

8.9 Мэдээлэлд үндэслэн сувилгааны онош (асуудал)-ыг тодорхойлж, тэмдэглэнэ. Ингэхдээ үйлчлүүлэгчтэй хамтарч шийдвэрийг гаргасан байна.

8.10 Тухайн оношд тохирох үйл, ажиллагааны төлөвлөгөөг хийнэ.

8.11 Төлөвлөгөөг хэрэгжүүлж, дүгнэх замаар сувилахуйн тусlamж, үйлчилгээг үзүүлнэ.

8.12 Авах арга хэмжээ, түүний давтамж, тодорхой үр дүнд хүртэл хэдэн удаа гэрээр тусlamж үзүүлэх, товтолыг тооцож тэмдэглэнэ.

8.13 Энэхүү товтолын дагуу сувилахуйн тусlamж үзүүлж, тухай бүрт үр дүнг тооцож, хийсэн бүх ажилбараа гэрээр сувилахуйн тусlamж, үйлчилгээ үзүүлсэн тухай тэмдэглэлд хөтөлнө.

8.14 Тусlamж, үйлчилгээг хэрхэн үзүүлсэн тухай товч, дүгнэн мэдэгдэж, үйлчлүүлэгчийн санаа бодлыг сонсох, асууж тодруулах, ойлгоогүй зүйл байгаа эсэхийг лавлаж, дараачийн товлолт хугацааг баталгаажуулснаар тухайн ажилбарыг дуусгавар болно.

8.15 Шаардлагатай тохиолдолд эмч дуудах, эсвэл олон мэргэжлийн багийн хэлбэрээр тусlamж, үйлчилгээг (сэтгэл засалч, хөдөлгөөн засалч, настны эмч, нийгмийн ажилтан) үзүүлж болно.

Ес. Гэрийн нөхцөлд хийх асаргаа, сувилгааны заалт.

Үйлчлүүлэгчийн сэтгэл санаа, орчин, нөхцөл, тав тухтай байдлыг алдагдуулахгүйгээр дор дурдсан өвчний заалтуудын үед гэрээр сувилахуйн тусlamж, үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

№	Тусламж, үйлчилгээний нэр	Эх сурвалж, анхаарах зүйлс
1. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ		
1	Зонхилон тохиолдож буй өвчин эмгэг, түүний давтамж, урьдчилан сэргийлэх асуудлаар танилцуулга, сээрэмжлүүлэг, зөвлөгөө өгөх	Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх бүхий байгууллагаар батлагдсан баримт бичиг,
2	Өртөмтгийн бүлгийн хүн амд эрсдэлт хүчин зүйлүүд түүнээс урьдчилан сэргийлэх арга барил эзэмшүүлэх сургалт, зөвлөмж өгөх	ДЭМБ болон олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн зөвлөмж ашиглана.
3	Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж, сургалт, сурталчилгааг явуулах, эрүүл амьдралын хэв маягт сургах, дадлагажуулах	
4	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж, сургалт, сурталчилгаа хийх	
5	Осол, гэмтэл, бэртлээс сэргийлэх, хүүхэд, настанд аюулгүй орчин бүрдүүлэх арга барилд сургах, зөвлөмж өгөх	
6	Хорт зурсил (архи, тамхи, мансууруулах бодис)-ын хор хөнөөл, урьдчилан сэргийлэх арга, ажиллагаа зохиох	
7	Бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх	
8	Томуу ба томуу төст өвчин, бүх нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлтийн үед гэрийн нөхцөлд хийх урьдчилан сэргийлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлэх	
9	Гэр бүлийн гишүүд болон хамт олонд эрүүл мэндийн боловсрол олгох, сургалт, сурталчилгаа, үзүүлэн таниулах, тараах материал түгээх	
10	Гэр бүл төлөвлөлтийн сургалт, сурталчилгаа хийх	
11	Гэр бүлийн гишүүд болон хамт олонд үзүүлэх эрүүл мэндийн боловсрол олгох, сургалт, сурталчилгаа, үзүүлэн таниулах, тараах материал гарын авлага түгээх	
12	Гамшиг осол, олон нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлт, онцгой байдлын үеийн сувилахуйн тусламж үйлчилгээний бэлэн байдлын удирдамж	
2. СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН БАЙГУУЛЛАГЫН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ		
1.	Бие бялдрын түвшин тогтоох сорил авах, анхаарал татсан хүүхдийг хяналтад оруулах, зөвлөмжөөр хангах	ХӨЦМ-ийн сургалтын материал,
2.	Сургуулийн насын хүүхдийн дархлаажуулалт, дархлаажуулалтын товлолын талаар мэдээлэл өгөх	Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх бүхий байгууллагаар батлагдсан баримт бичиг,
3.	Хүүхдэд эрүүл ахуйн дадал хэвшүүлэх (гар угаах, шүд угаах, амны хөндийн эрүүл мэнд, орчны эрүүл мэнд) сургалт явуулах	
4.	Дунд ахлах ангийнханд бэлгийн хөгжлийн боловсрол, БЗДХ-аас сэргийлэх сургалт явуулах	
5.	Хорт зурсил, мансууруулах бодисын хорт чанарын талаар сургалт явуулах	

6.	Сургууль цэцэрлэгийн байгууллагад эрүүл мэндэд ээлтэй орчин, нөхцөл бүрдүүлэх цогц зөвлөгөө өгөх	ДЭМБ болон олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн зөвлөмж ашиглана.
----	--	--

3. НЯРАЙ ХҮҮХДЭД ГЭРЭЭР ҮЗҮҮЛЭХ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

1.	Нярайн хоол, тэжээлийн талаар зөвлөмж өгөх	ХӨЦМ-ийн сургалтын материал, Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх бүхий байгууллагаар батлагдсан баримт бичиг, ДЭМБ болон олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн зөвлөмж ашиглана.
2.	Зөв хөхүүлэх арга барил заах, зөвлөгөө өгөх	
3.	Нярайн ерөнхий асаргаа, эрүүл бойжуулах зөвлөмж өгөх (орчны чийгшил, агааржуулалт, дулаан, арьс арчлах, хувцаслах,)	
4.	БЦЖ вакцины сорвижилт, түүнийг үнэлэх зөвлөгөөг гэр бүлийн гишүүдэд өгөх	
5.	Нярайд хүчилтөрөгч өгөх, амьсгалын замыг чөлөөлж, цэр соруулах	
6.	Нярайн рефлексийг үзэж, үнэлэх	
7.	Нярайг жигнэх, урт өндрийг хэмжих	
8.	Түнхний үений мултралын эрдэлтэй нярайд өвөрмөц сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлэх	
9.	“0-2” хүртэлх насны хүүхдийг багцын жингээр жинлэх	
10.	Шинэ төрсөн нярайг амлуулах	
11.	Бага жинтэй нярайг “имж-эх” аргаар дулаацуулах	
12.	Нярай хүүхдийг усанд оруулах	
13.	Нүд цэвэрлэх, нүдэнд эм дусаах	MNS 4621:2008
14.	Нярай хүүхдийн амны хөндий цэвэрлэх	
15.	Нярай хүүхдийн хамар цэвэрлэх, хамарт эм дусаах	
16.	Нярай хүүхдэд эм уулгах	
17.	Нярай хүүхдийн хүйг цэвэрлэх	
18.	Арьсны тууралттай нярай хүүхдийн асаргаа, сувилгаа	
19.	Нярай хүүхдэд гич наах	
20.	Нярай хүүхдийн цээжинд доргiox ба тогших иллэг хийх	
21.	Нярай хүүхдийн захын хураагуур судсанд уян зүү тавих	
22.	Нярай хүүхдийн шээсийг шинжилгээнд авахад бэлтгэх, шинжилгээнд авах	
23.	Нярай хүүхдийн шээсийг нян судлалын шинжилгээнд авахад бэлтгэх, шинжилгээнд авах	
24.	Нярай хүүхдийн баасыг нян судлалын шинжилгээнд авахад бэлтгэх, шинжилгээнд авах	

4. ХҮҮХДЭД ГЭРЭЭР ҮЗҮҮЛЭХ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

1.	Хүүхдийн урт буюу өндрийг хэмжих	ХӨЦМ-ийн сургалтын материал Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх бүхий
2.	Хүүхдэд халуун, хүйтэн жин, бигнүүр тавих	
3.	Захын хураагуур судсанд уян зүү тавих, заавар өгөх	
4.	Шингэн алдалтын үеийн асаргаа, сувилгаа, шингэн сэлбэх, давсны уусмал бэлдэж уулгахыг заах	
5.	Эцэг, эх, гэр бүлийн гишүүдэд хүүхдийн эрүүл мэндэд хүрээлэн	

	буй орчны нөлөөний талаар зөвлөмж, сургалт, сурталчилгаа хийх	байгууллагаар батлагдсан баримт бичиг,
6.	Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүүхдэд асаргаа, сувилгаа, дасгал, хөдөлгөөн засал хийх, эцэг эх асран хамгаалагчид зөвлөмж, сургалт хийх	ДЭМБ болон олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн зөвлөмж ашиглана.
7.	Бие, физиологийн өсөлтийн сааталттай хүүхдэд дасгал, хөдөлгөөн, асаргаа, сувилгаа хийх, эцэг эх асран хамгаалагчид зөвлөмж, сургалт хийх зөвлөмж, сургалт хийх	
8.	Хүүхдийн хоол тэжээл, хэмжээ, тэжээллэг чанар, хооллолтын талаар хийх, эцэг эх асран хамгаалагчид зөвлөмж, сургалт хийх	
9.	Хүүхдийн өдрийн дэглэм, цаг хуваарилалтын талаар эцэг эх асран хамгаалагчид зөвлөмж, сургалт хийх	
10.	Хүүхдийн гэрийн асаргааны зарчмуудыг эцэг эхэд биечлэн үзүүлж сургах	
11.	Амьсгалын замын өвчтэй хүүхдэд сувилахуйн тусlamж үзүүлэх заавар өгөх	Зонхилон тохиолдох эмгэгийн үед үзүүлэх сувилахуйн тусlamжийн удирдамж /НЭМГ, 2009/
12.	Суулгальттай хүүхдийг үнэлж, шингэн алдалтгүй суулгальтыг гэрээр сувилах	
13.	Сульдаатай хүүхдийг сувилах	
14.	Тураалтай хүүхдийг сувилах	
15.	Шүүдэст эмзэгшилтэй хүүхдэд сувилахуйн тусlamж үзүүлэх	
16.	Хэрлэг өвчтэй хүүхдэд сувилахуйн тусlamж үзүүлэх	Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх бүхий байгууллагаар батлагдсан баримт бичиг

5. ЖИРЭМСЭН ЭМЭГТЭЙ, ТӨРСӨН ЭХ, НЯРАЙД ҮЗҮҮЛЭХ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

1.	Жирэмсэн эмэгтэйн биеийн байдлыг үнэлэх, сувилахуйн тусlamж үзүүлэх	Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх бүхий байгууллагаар батлагдсан баримт бичиг,
2.	Эрүүл жирэмсэн эмэгтэйг хянах, төрөлтөд бэлтгэх, урьдчилан сэргийлэх дасгал, хөдөлгөөн засал, сэтгэл засал, хоол засал, гэр бүлийн гишүүдэд сургалт зохиох	Зонхилон тохиолдох эмгэгийн үед үзүүлэх сувилахуйн тусlamжийн удирдамж /НЭМГ, 2009/,
3.	Бөөрний эмгэгтэй жирэмсэн эмэгтэй, төрсөн эхэд сувилахуйн тусlamж үзүүлэх	
4.	Элэгний үрэвсэлтэй жирэмсэн эмэгтэй, төрсөн эхэд сувилахуйн тусlamж үзүүлэх	
5.	Гуурсан хоолойн үрэвсэлтэй жирэмсэн эмэгтэй, төрсөн эхэд сувилахуйн тусlamж үзүүлэх	
6.	Зүрх судасны эмгэгтэй жирэмсэн эмэгтэй, төрсөн эхэд сувилахуйн тусlamж үзүүлэх	ДЭМБ болон олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн зөвлөмж ашиглана.
7.	Төрсний дараа зонхилон тохиолдох хүндрэлүүдийн үед эхэд сувилахуйн тусlamж үзүүлэх	
8.	Сүрьеэ өвчтэй жирэмсэн эмэгтэй, төрсөн эхэд сувилахуйн тусlamж үзүүлэх	
9.	Дотоод шүүрлийн эмгэгтэй жирэмсэн эмэгтэй, төрсөн эхэд сувилахуйн тусlamж үзүүлэх	
10.	Төв мэдрэлийн системийн эмгэгтэй жирэмсэн эмэгтэй, төрсөн	

	эхэд сувилахуйн тусламж үзүүлэх	
11.	Нефрозын хам шинжтэй жирэмсэн эмэгтэй, төрсөн эхэд сувилахуйн тусламж үзүүлэх	
12.	Хүндрэлтэй жирэмсэн эмэгтэйн хооллолт, жирэмсний онцлог үеүдэд хийгдэх дасгал, хөдөлгөөн, гэр бүлийн гишүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохиох	

6. НАСТАНД ҮЗҮҮЛЭХ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

1	Настанд сувилахуйн тусламж үзүүлэх	Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх бүхий байгууллагаар батлагдсан баримт бичиг, ДЭМБ болон олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн зөвлөмж ашиглана.
2	Настанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээр үзүүлэх олон мэргэжлийн багийн үйл ажиллагаа явуулах	

7. ШҮДНИЙ ӨВЧНИЙ ҮЕИЙН СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

1	Амны хөндийн салстын өвчний үед сувилахуйн тусламж үзүүлэх	Зонхилон тохиолдох эмгэгийн үед үзүүлэх сувилахуйн тусламжийн удирдамж /НЭМГ, 2009/
2	Шүдний тойрон эдийн үрэвслийн үед сувилахуйн тусламж үзүүлэх	
3	Шүдний цоорлын үед сувилахуйн тусламж үзүүлэх	

8. ЧИХ, ХАМАР ХООЛОЙН ӨВЧНИЙ ҮЕИЙН СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

1.	Чихэнд эм дусаах	MNS 4621:2008
2.	Чихэнд бигнүүр тавих	
3.	Чих цэвэрлэх	
4.	Чихний хатсан хулхийг цэвэрлэх ба гадны биетийг авах	
5.	Хамарт эм дусаах	
6.	Хамрын хөндийг угаах	
7.	Хамарт нунтаг эм цацах	
8.	Хамарт шавшлага хийх	
9.	Хамарт өмнөд чихээс тавих	
10.	Хамрын арын чихээс хийх	
11.	Хоолойд бүлээсгэх боолт хийх, бигнүүр тавих	
12.	Хоолой зайлах	
13.	Хоолойд эм түрхэх	
14.	Хоолой утах	
15.	Хоолойд эм цацах	

9. НҮДНИЙ ЭМГЭГИЙН ҮЕД ҮЗҮҮЛЭХ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

1.	Нүдэнд эм дусаах ба нүд угаах	MNS 4621:2008
----	-------------------------------	---------------

2.	Нүдэнд ганц ба хос боолт хийх	
3.	Харааны чадал шалгах	
4.	Өнгө таних чадварыг шинжлэх	
5.	Нүдний хараа тогтоох, сэргээх дасгал, хөдөлгөөн заах	

10. СЭТГЭЦИЙН ЭМГЭГИЙН ҮЕИЙН СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

1	Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн үеийн сувилахуйн тусlamж, үйлчилгээг үзүүлэх	Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх бүхий байгууллагаар батлагдсан баримт бичиг, ДЭМБ болон олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн зөвлөмж ашиглана.
---	--	--

11. ЕРӨНХИЙ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАРДАН ҮЙЛДЭЛ

1.	Амьсгал тоолох	MNS 4621:2008
2.	Биеийн халуун хэмжих	
3.	Судасны цохилт тоолох	
4.	Артерийн даралт үзэх	
5.	Биеийн өндөр, жин үзэх	
6.	Бумба тавих	
7.	Гич наах	
8.	Халуун хүйтэн жин, бигнүүр тавих	
9.	Цэвэрлэх бургуй тавих	
10.	Тэжээлийн бургуй тавих	
11.	Бичил бургуй тавих	
12.	Хий гаргах гуурс тавих	
13.	Утлага хийх	
14.	Трахеостомийг арчлах	
15.	Цэр, салс соруулах	

12. ЭРХТЭН СИСТЕМИЙН ӨӨРЧЛӨЛТТЭЙ НАСАНД ХҮРЭГЧДЭД ГЭРЭЭР ҮЗҮҮЛЭХ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

1.	Амьсгалын замын өвчтэй хүнд сувилахуйн тусlamж үзүүлэх	Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх бүхий байгууллагаар батлагдсан баримт бичиг,
2.	Зүрх судасны өвчтэй хүнд сувилахуйн тусlamж үзүүлэх	
3.	Бөөр шээсний замын өвчтэй хүнд сувилахуйн тусlamж үзүүлэх	
4.	Элэгний архаг үрэвсэлтэй өвчтөнд сувилахуйн тусlamж үзүүлэх	
5.	Цөсний өвчтэй хүнд сувилахуйн тусlamж үзүүлэх	
6.	Саа, саажилттай хүнд сувилахуйн тусlamж үзүүлэх	
7.	Чихрийн шижинтэй хүнд үзүүлэх сувилахуйн тусlamж (цусан дахь сахар үзэх, хөлөө шалгах, хөлийн хумс авах, гутал сонгох, инсулиний зөвлөмж, цусны даралтаа хянах, хоолны дэглэм, эмийн хэрэглээний талаар зөвлөмж)	

Зонхилон тохиолдох эмгэгийн үед үзүүлэх сувилахуйн тусlamжийн удирдамж /НЭМГ,

		2009/, ДЭМБ болон олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн зөвлөмж ашиглана
--	--	--

13. ХҮНД, ХЭВТРИЙН ӨВЧТӨНД ГЭРЭЭР ҮЗҮҮЛЭХ СУВИЛАХҮЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

1.	Үйлчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх, сувилахуйн мэргэжлийн цогц тусlamж, үйлчилгээ үзүүлэх	Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх бүхий байгууллагуудаар батлагдсан баримт бичиг, ДЭМБ болон олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн зөвлөмж ашиглана.
2.	Гэр бүлийн гишүүдийг хэвтрийн хүнд өвчтөнийг асрахад сургах	
3.	Хэвтрийн өвчтөний байрлал өөрчлөх, хөдөлгөх, холголт цооролтоос урьдчилан сэргийлэх тусlamж, үйлчилгээ үзүүлэх	
4.	Өвчтөнийг орноос буулгах, суулгах, түшлэгтэй сандалд суулгах, бие засах газрын суултуур, хөтөвчинд суулгах, салхилуулах	
5.	Унаж бэртэхээс сэргийлэх, үйлчлүүлэгчийг салхилуулах, үйлчлүүлэгчтэй ярилцах, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх	
6.	Хэвтрийн өвчтөний бүтэн биеийн угаалга хийх	
7.	Хэсэгчилсэн угаалга (толгойн үс, шүд, ам, нүүр, бэлэг эрхтэн)	
8.	Эмэгтэйчүүдийн өвчний үед утрээг угаах, цацлага, эмийн бодис хэрэглэх	

14. СЭРГЭЭН ЗАСАХ СУВИЛАХҮЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

1.	Бүх биеийн иллэг, бария, толгой, хүзүүний иллэг, бария	Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх бүхий байгууллагаар батлагдсан баримт бичиг, ДЭМБ болон олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн зөвлөмж ашиглана.
2.	Биеийн ерөнхий байдал сайжруулах, бүх төрлийн эмийн бус тусlamж, үйлчилгээ, нөхөн сэргээх дасгал хөдөлгөөн, хоол эмчилгээ	
3.	Сэргээн засах сувилгаа (Хийн дасгал, биеийн тамир эмчилгээ, бария засал, хөдөлгөөн засал гэх мэт)	
4.	Саажилттай өвчтөнд дасгал хөдөлгөөн зааж сургах	
5.	Хөгжлийн бэрхшээлтэй болон осол гэмтлийн дараах байдалтай байгаа үйлчлүүлэгчид бие даах, өөрийгөө асрах чадварт сургах, дасгал хөдөлгөөн заах, зөвлөгөө өгөх	
6.	Зөгийн балтай татлага	
7.	Биеийн хөшингө гаргах, татлага хийх, хөдөлгөөн засал	
8.	Эмчилгээний биеийн тамирын дасгал, хөдөлгөөн заах	
9.	Биед хэсэгчилсэн болон бүх биенд иллэг хийх	
10.	Тосон болон сүүн бария хийх	
11.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тэргэнцэр хэрэглэж сургах	
12.	Өвчний хурц үеийн дараах үлдэц, цаашид эмчилгээ сувилгаа, хяналтыг гэрийн нөхцөлд урт хугацаагаар үргэлжлүүлэх эмчийн заалттай үйлчлүүлэгчид үзүүлэх сувilaхуйн тусlamж	
13.	Мэс заслын дараах нөхөн сэргээх асаргаа, сувилгаа	
14.	Өвчтөнийг шинжилгээнд бэлтгэх	
15.	Цус, шээсний ерөнхий шинжилгээ авах	
16.	Цөс угаах	
17.	Эм уулгах	
18.	Шулуун гэдсээр эм хэрэглэх	

19.	Арьс салстад эмийн бодис хэрэглэх (шавших, угаах, турхэх)
20.	Шээс задгайрсан үед авах сувилахуйн тусlamж
21.	Давсганд шээлгүүр тавих
22.	Өтгөн хаталттай өвчтөний сувилахуйн тусlamж, үйлчилгээ
23.	Өтгөн задгайрсан үед үзүүлэх сувилахуйн тусlamж, үйлчилгээ
24.	Хооллолтын бэрхшээлтэй өвчтөний сувилахуйн тусlamж, үйлчилгээ

15. ӨДӨР ТУТМЫН АСАРГАА, СУВИЛГАА

1.	Орны цагаан хэрэглэл солих, ор цэвэрлэх	Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх бүхий байгууллагаар батлагдсан баримт бичиг, ДЭМБ болон олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн зөвлөмжүүдийг ашиглана.
2.	Үс самнах, усанд оруулах	
3.	Хувцас солих (дотуур, гадуур) хувцаслах	
4.	Нэг удаагийн ариун цэврийн хэрэглэл солих (памперс, тампон)	
5.	Нэг удаагийн ариун цэврийн хэрэглэл тавих, солих, арчилгаа (колопласт, иелопласт, шээлгүүр)	
6.	Толгойг угаах	
7.	Амны хөндий арчлах	
8.	Цагаан хэрэгсэл солих	
9.	Хэвтриний өвчтөнийг хооллох	

16. ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ

1.	Зөв хооллолт, хөдөлгөөн, артерийн даралт, болон цусан дахь сахарыг гэрээр өөрөө хянах	Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх бүхий байгууллагаар батлагдсан баримт бичиг, ДЭМБ болон олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн зөвлөмж ашиглана.
2.	Үйлчлүүлэгчийн ар гэрийнхэнд сургалт явуулах (Эм тогтмол уух, хэвтриний үйлчлүүлэгч, харвалтын дараах нөхөн сэргээх, бие даах чадварыг сайжруулах, хооллолт болон шингэний баланс тооцох)	
3.	Сэтгэл засал, зөвлөгөө өгөх сувилахуй	
4.	Эрүүл, аюулгүй амьдрах орчин, нөхцөл бүрдүүлэх, эрүүл амьдралын хэв, маяг бүрдүүлэх зөвлөгөө өгөх	
5.	Эрүүл мэндийн боловсрол олгох бусад сургалт, сурталчилгаа	

17. ГЭМТЭЛ, БЭРТЛИЙН ДАРААХ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

1.	Төрөл бүрийн гэмтлийн мөчдийн боолт	Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх бүхий байгууллагаар батлагдсан баримт бичиг, ДЭМБ болон олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн зөвлөмж ашиглана.
2.	Төрөл бүрийн мэс заслын шархны боолт солих, оёдол авах	
3.	Гэмтэл, бэртэлт, цус алдалтын үед авах анхны тусlamж	
4.	Цэр ховхлох, утлага хийх, механик аргаар гаргах	
5.	Гэдэс дүүрэлтийг намдаах даралтат иллэг	
6.	Өвчтөн амирлах үеийн бие засал, гэр бүлийн уй гашууг хуваалцах, нимгэлэх, зөвлөгөө өгөх	

18. ЭМЧИЙН ЗААЛТААР ХИЙХ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

1.	Арьсан дор тарилга хийх	MNS 4621:2008
2.	Булчинд тарилга хийх	
3.	Судсанд тарилга хийх	
4.	Дуслаар шингэн сэлбэх	
5.	Арьсан дотор тарилга хийх	
6.	Хураагур судас хатгаж, шинжилгээнд цус авах	
7.	Үйлчлүүлэгчид гич наах	
8.	Үйлчлүүлэгчид бумба тавих	
9.	Үйлчлүүлэгчид цэвэрлэх бургуй тавих	
10.	Үйлчлүүлэгчийн амьсгал тоолох	
11.	Үйлчлүүлэгчийн халуун хэмжих	
12.	Үйлчлүүлэгчийн ходоод угаах	
13.	Үйлчлүүлэгчид шээлгүүр тавих	
14.	Ходоод гэдэс угаах, эмчилгээний бургуй тавих	
15.	Гэдэсний хий гаргах гуурс тавих	
16.	Давсаг угаах, шээс авах (эмчийн заалтаар)	Эмчийн хяналт, зөвлөмжийн дор
17.	Ходоод хаймсуурдах, угаах (эмчийн хяналт дор)	
18.	Цөсний хүүдийн хаймсуурдах, угаах (эмчийн хяналт дор)	
19.	Эмчийн зөвшөөрөл бүхий бусад эмийн эмчилгээ	
20.	Эмчийн заалтаар гэрийн нөхцөлд үзүүлэх бусад тусlamж, үйлчилгээ	

Арав. Үйлчлүүлэгчид гэрээр үзүүлэх сувилахуйн тусlamж, үйлчилгээний эсрэг заалт.

10.1 Үйлчлүүлэгчийн өвчин эмгэг нь амь насанд шууд аюул учруулахаар байгаа тохиолдол,

10.2 Үйлчлүүлэгч ухаангүй, маш хүнд, оврогын байдалтай байгаа,

10.3 Үйлчлүүлэгч өөрөө гэрээр үзүүлэх асаргаа сувилгааны нөхцөл, заалтуудын талаар урьдчилан танилцуулсан боловч зөвшөөрөл өгөөгүй бол /зөвшөөрлийг гэрийн сувилгааны түүхэнд хавсаргасан байна/

10.4 Үйлчлүүлэгч, ялангуяа хүүхэд, нярай болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд гэрээр сувилахуйн тусlamж, үйлчилгээ үзүүлж байх явцад дэргэд нь гэр бүлийн аль нэг гишүүн хамт байх боломжгүй байх,

10.5 Эмчийн заалтаар үзүүлэх тусlamжид эмчийн заалтгүй бол.

Арван нэг. Халдвартын сэргийлэлт, хяналтын дэглэмийг мөрдөхөд сувилагчийн баримтлах эрх зүйн баримтууд.

Баримтлах стандарт		Эх сурвалж
1	“Эрүүл мэндийн байгууллагуудад халдвартайжүүлэх бодисын жилийн хэрэгцээг тооцох аргачлал”	Эрүүл мэндийн сайдын 2012 оны 192 дугаар тушаал
2	“Журам батлах тухай”-халдвартын сэргийлэлт, хяналт	Эрүүл мэндийн сайдын 2014 оны 186 дугаар тушаал
3	“Заавар батлах тухай”-халдвартын сэргийлэлт, хяналт	Эрүүл мэндийн сайдын 2014 оны

4	Гар угаах	187 дугаар тушаал MNS 4621:2008
5	Бээлий өмсөх	
6	Гардан үйлдэл хийхэд баримтлах ерөнхий зарчим	
7	Тарилга хийхэд баримтлах аюулгүй ажиллагаа	
8	Туншлаас эмийн бодис соруулж тарих арга техник	
9	Флаконтой эмийг найруулж тария хийх	

Арван хоёр. Хяналт, үнэлгээ.

12.1 Сувилагч үзүүлсэн тусламж, үйлчилгээндээ хариуцлага хүлээх үүднээс үйлчилгээ үзүүлсэн тохиолдол бүрт захиалга бүртгэлийн хуудас, сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлсэн тухай тэмдэглэлийн маягтыг үнэн зөв хөтлөх, хөтөлсөн хуудсыг хадгалах, хамгаалах хариуцлага хүлээнэ.

12.2 Эрүүл мэндийн байгууллага, тусламж, үйлчилгээ үзүүлсэн сувилагч өөрөө болон, хөндлөнгийн байгууллагаас хийсэн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа нь тусламж, үйлчилгээний чанарыг нотлох гол шалгуур байна.

12.3 Сувилгааны үр дүнг ижил мэргэжилтний багаар хэлэлцэж, цаашид авах арга хэмжээг төлөвлөх, хамтарсан шийдвэр гаргах, чанарын үнэлгээний зарчмыг хэрэгжүүлнэ.

12.4 Гэрээр үзүүлсэн сувилахуйн тусламж, үйлчилгээний хэрэгжилтэд тухайн багийн ахлагч, ахлах сувилагч, сувилгааны алба, чанарын алба хяналт тавьж, үр дүнг сар бүр тооцож, харьяа байгууллагын хагас, бүтэн жилийн тайланд тусган, хэлэлцүүлж үр дүнг байнга тооцож ажиллана.




Эрүүл мэндийн сайдын
2017 оны 01 сарын 26-ны өдрийн
4/4 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

ГЭРЭЭР СУВИЛАХҮЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЗАХИАЛГА
БҮРТГЭЛИЙН ХУУДАС

Хүсэлт гаргагчийн овог, нэр _____
Холбоо барих утас: Гэр _____
Гэрийн хаяг: _____

Гэрээр сувилахуйн тусlamж авахыг хүсч байгаа зорилго, шалтгаан				Захиалга ёгсөн				Захиалга хулээн авсан				Гэрээр тусламж, үйлчилгээ үзүүлэхийг:		
Огноо	Цаг минут	Огноо	Цаг минут	Огноо	Цаг минут	Цаг минут	Шалтгаан тодорхой бичих	Зөвшөөрсөн	Шалтгаан тодорхой бичих	Зөвлөгөө өгөөд захиалтыг цуцалсан шалтгаан тодорхой бичих	Гарын үсэг	Захиалга ёгчийн: Нэр	Захиалтыг биеэр ирж ёгсөн утсаар авсан /доогуур нь зурах/	
Захиалга хулээн авсан эмч, сувилагч /доогуур нь зурах/-ийн хэзээ очих товтол, тэмдэглэл														
Захиалгыг хүлээж авсан эмч/сувилагч /доогуур нь Нэр:														



~~2017 оны 4 сарын 26-ны өдрийн
14/1 дугаар тушаалын 3 дуаар~~

ГЭРЭЭР СУВИЛАХҮЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛСЭН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

A. HYDREH TARI

Үйлчлүүлэгчийн овог нэр			
Nas	Xүйс	Хүйс	Эмчийн онош, заалт
Огноо	Үнэлгээ /бодит үзлэгээр илэрсэн асуудал, асуулт, ярилцлага, үйлчлүүлэгчийн санал хүсэлт, шинжилгээний хариу	Гол асуудал буюу сувилгааны онош	Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн тусlamж, үйлчилгээ, анхаарах зүйлс
Эхэлсэн	Дүүссан		

Б. АРТАЛ

Эхэлсэн /дүүссан /цагмийн/	Төлөвлөгөөг хэрэгжүүлсэн тухай аргаалал	Хүрсэн үр дүн, дахин хэзээ тусlamж, үзүүлэх давтамж	Үйлчлүүлэгчид, ёгсоон зөвлөгөө, анхаарах зүйлсийн талаар тэмдэглэл	Сувилагчийн гарын үсэг